



Танд тусламж хэрэгтэй байна уу? Бид танд туслахад бэлэн байна.

Хэрэглэгчийн үйлчилгээний төв - Танд хэрэгцээ гарсан үед утсаар эсвэл биечлэн холбогдох анхны цэг. Бидэнтэй 703-228-1300 утсаар холбогдож эсвэл Виржини муж 22204, Арлингтон, 2100 Вашингтон Бульвар, 1 давхарт ирж бидэнтэй уулзана уу.

Нийгмийн болон орон сууцаар хангах тусламж - Үйлчилгээнд албадан нүүлгэхээс сэргийлэхийн тулд байр түрээслэхэд туслах хөтөлбөр ба үйлчилгээ, нийтийн үйлчилгээг нь зогсоохоос сэргийлэх нийтийн үйлчилгээний тусламж, эмчилгээний төлбөр зэрэг багтана. Үйлчилгээг шалгуур үзүүлэлтээс хамаарч үзүүлэхийг анхаарна уу.

Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ - Ажлын байрны яармагийн мэдээлэл ашиглах, ажил мэргэжлийн үнэлгээний тусламж, компьютер, принтер, Microsoft Word, Excel програмын хичээлүүд, ажилд бэлтгэх семинар, <https://jobboard.arlingtonva.us/> вебсайтаас боломжтой ажил хайх.

Ажиллах хүчний сургалт - "Бусад хэлээр ярьдаг хүмүүст зориулсан Англи хэлний" анги болон бусад ажлын байрны сургалтын хөтөлбөрт хамрагдах тэтгэлэг.

Орон гэргүй хүмүүс ба түр амьдрах байраар хангах үйлчилгээ - Арлингтон дүүргийн орон гэргүй болсон оршин суугчдад зориулсан хувь хүн, гэр бүлүүдийг түр амьдруулах байр.

Эмнэлгийн тусламж - Бүх насны, бага орлоготой оршин суугчдад зориулсан эрүүл мэндийн даатгал.

Үл хөдлөх хөрөнгийн татварын хөнгөлөлт - 65 ба түүнээс дээш насны бага, дунд орлоготой орон сууцны эзэд, эсвэл байнгын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг татвараас чөлөөлөх, татварыг нь хойшлуулах.

Нийгэмд хүрч ажиллах хөтөлбөр - Нийгэмд төрөл бүрийн үйлчилгээ, нөөцийн тусламж үзүүлдэг. Шинээр ирсэн хүмүүст зориулсан арга хэмжээ, сургалтууд болон нийтийн хэрэгцээнд үндэслэн байнгын үйлчилгээ зохион байгуулдаг. Хүрч ажиллах мэргэжилтнүүд олон соёл, олон хэлтэй бөгөөд Арлингтоны оршин суугчдад олон саад бэрхшээлийг даван туулахад нь туслах туршлагатай. Ажилтнууд хоол хүнс, живхний нөөцийн банкинд лавлагаа өгөх, өргөдөл гаргахад туслаж, нотариатын үйлчилгээ үзүүлдэг.

Олон нийтийн тусламж үзүүлэх - Хүнсний тусламж, санхүүгийн тусламж, нийтийн үйлчилгээний тусламж, эмнэлгийн тусламж, хүүхэд асрах зэрэг богино хугацааны болон/эсвэл түр зуурын хэрэгцээнд туслах олон нийтийн аюулгүй байдлын сүлжээ хөтөлбөрүүд. Хөтөлбөрүүд нь хүүхэд, гэр бүл, хувь хүмүүст дэмжлэг үзүүлдэг. Бүх олон нийтийн тусламжийн хөтөлбөрүүд нь санхүүгийн болон санхүүгийн бус шалгуурыг хангах удирдамжтай байдаг. Виржини муж 22204, Арлингтон, 2100 Вашингтон Бульвар, <https://www.commonhelp.virginia.gov>, эсвэл 855-635-4370 утсаар биечлэн өргөдөл гаргана уу.

Нэмэлт хоол тэжээлийн тусламжийн хөтөлбөр (SNAP) - Хүнс худалдан авахад санхүүгийн дэмжлэг үзүүлдэг.

Гачигдалтай гэр бүлүүдэд үзүүлэх түр тусламж (TANF) - Орлого нь хүүхдүүдийнхээ хэрэгцээг хангахад хэт бага гэр бүлүүдэд үзүүлэх санхүүгийн дэмжлэг.

ДЭЛГЭРЭНГҮЙ ҮЗЭХ

Арлингтоны Хүний
үйлчилгээний хэлтэс
2100 Вашингтон Бульвар.,
22204 Виржини муж, Арлингтон
www.arlingtonva.us/dhs

Машины зогсоол
ХҮХ-ийн үйлчлүүлэгчид Секуа Плаза
дахь үнэгүй машины зогсоолыг
(цэнхэр түвшний) хэрэглэх
боломжтой. Хэрэв машины зогсоол
дүүрсэн бол гудамжны зогсоолыг
ашиглана уу.

**Нийтийн тээврийн
сонголтууд:**
ART 42, ART 45, ART 77

Утас:
703-228-1300
703-228-1398 ТТҮ

Арлингтон Дүүрэг нь холбооны иргэний эрхийн тухай хууль тогтоомжийг дагаж мөрддөг бөгөөд арьс өнгө, үндэс угсаа, нас, хөгжлийн бэрхшээл, хүйсээр ялгаварлан гадуурхдаггүй. Хүсэлт гаргаж хэлний үйлчилгээ авах боломжтой.



ARLINGTON
VIRGINIA
Human Services